



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/651

Булган сум

┌ Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах зардлын ┐
хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” XXV/05 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралтын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан “Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах” зардлын хуваарьт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” XXV/05 дугаар тогтоолоор нэмэлт хөрөнгө оруулалт тусгагдсан тул аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/464 тоот захирамжийн хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж шинэчилсүгэй.

2. Хавсралтаар батлагдсан зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгавар, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг хууль, журмын дагуу зохион байгуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т, Худалдан авах ажиллагааны газар (Б.Баярцэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.

3. “Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу тухай бүр нь аймгийн орон нутгийн төсвийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010902

10 дугаар сарын 08-ны өдрийн А/65 дугаар захирамжийн хавсралт



Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээ, ажлын зураг төсөв боловсруулах зардлын шинэчилсэн хуваарь

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Зураг төсөл боловсруулах зардал	Тайлбар
1	2	3	4
Бодлогын баримт бичиг.			
1	Булган аймгийн барилга, хот байгуулалтын дунд хугацааны бодлогын баримт бичиг бөгөөд сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	65,000,000.00	Аймгийн 16 сум, 1 тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэнтэй холбогдуулан Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйл. 11.1.6.хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5 жилийн төлөвлөгөө боловсруулах.
<i>Хэсгийн дүн</i>		65,000,000.00	
Барилга			
2	Хангал сумын Хялганат тосгоны сум дундын Цагдаагийн тасгийн кабоны шинэ барилга	20,000,000.00	АИТХ-ын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн XX/06 дугаар тогтоолын 3 дахь заалт. Монгол Улсын 21 аймаг, 330 сумын хэмжээнд хамгийн муу ашиглалтын шаардлага, стандарт хангахгүй барилгатай.
3	Могод сумын "Баясгалант" 2-р багийн Хөгжлийн төвийн барилгын зураг төсвийн санхүүжилт	11,850,000.00	Могод сумын Засаг даргатай "Зууны гүүр" ХХК тус багийн хөгжлийн барилгын зурагийн гэрээ байгуулсан зургийн санхүүжилтийг АИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн XXV/05 дугаар тогтоолоор нэмэгдсэн.
4	"Махны үйлдвэрийн цогцолбор"-ын барилга, байгууламжийн ТЭЗҮ, ажлын зураг төсөв боловсруулах.	29,500,000.00	Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, Аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5.1.2.1-т тусгагдсан. Нийт төсөвт өртөг 140,0 сая төгрөг үүнээс үлдэгдэл 110,0 сая төгрөгийг төсвийн тодотгол, төсөл хөтөлбөр, барилга угсралтын зардал, бусад эх үүсвэрээс гэрээнд заагдсан үлдэгдэл үнийн дүнгээр санхүүжүүлнэ.
<i>Хэсгийн дүн</i>		61,350,000.00	
Инженерийн дэд бүтэц			
5	Булган суманд барилгажсан хэсгүүдэд хэрэгцээний халуун усны хангамжийг үе шаттай хэрэгжүүлэх.	19,900,000.0	16, 17, 208-р орон сууц. Аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.4.6.1-т тусгагдсан. Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/49 дугаар захирамжийг санхүүжүүлэх зардал

6	Булган сумын 4-р баг Зүүн түрүүний голын төмөр бетон гүүр, эргийн бэхлэгээний зураг төсөл боловсруулах.	80,000,000.0	Булган аймгийн Онцгой комиссын 2024 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэлийн 5.1 дэхь хэсэг, Авто замын хяналтын улсын байцаагчийн 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 04-17-02/131/01 дугаар дүгнэлт. АИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн XXV/05 дугаар тогтоолоор нэмэгдсэн.
7	Тэшиг сумын Эгийн голын эргийн бэхлэгээ.	20,000,000.0	АИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн XXV/05 дугаар тогтоолоор нэмэгдсэн.
8	Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	28,000,000.0	Булган аймгийн Онцгой комиссын 2024 оны 08 дугаар сарын 13-ний өдрийн 48, 2024 оны 09 дугаар сарын 12-ний өдрийн 63 тоот албан бичиг, Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 02-17-01/055/14 тоот дүгнэлт. АИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн XXV/05 дугаар тогтоолоор нэмэгдсэн.
9	Сэлэнгэ сумын хатуу хучилттай авто зам.	100,000,000.0	Сэлэнгэ сумын Засаг даргатай 2024 оны 07 дугаар сарын 03-ний өдрийн 04/24 тоот гэрээний санхүүжилт. АИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн XXV/05 дугаар тогтоолоор 70.0 сая төгрөг нэмэгдсэж 100.0 сая төгрөг болсон.
10	Бүрэгхангай сумын 10кв-ын ЦДАШ, 10/0.4 дэд станцын ажил	16,000,000.0	Шинээр үүссэн сууршлын бүсийн цахилгаан хангамж
11	Хутаг-Өндөр сумын Тээл 4-р багийн шинэ сууршлын бүсийн цахилгаан хангамж	16,200,000.0	Шинээр үүссэн сууршлын бүсийн цахилгаан хангамж
<i>Хэсгийн дүн</i>		<i>280,100,000.00</i>	
Их засвар.			
12	Булган сумын Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын засвар, шинэчлэлийн ажил	12,000,000.0	Аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.4.4.2-т тусгагдсан. Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/49 дугаар захирамжийг санхүүжүүлэх зардал
13	Нэгдсэн эмнэлгийн лифт, хүлээн авахын хэсгийн засвар	19,800,000.0	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт стандартын шаардлага хангасан лифт суулгаж тэргэнцэртэй болон хэвтэн эмчлүүлэх иргэдийнг зөөвөрлөх. Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/49 дугаар захирамжийг санхүүжүүлэх зардал
14	Булган сумын төвийн дулааны ДХ143 - ДХ129-р худаг чиглэлийн 5 хос шугам өргөтгөх, шинээр хийх ажил	15,375,058.0	Барилгын техник хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарсан.
15	Булган сумын төв халуун усны барилгын засвар	19,000,000.0	Барилгын техник хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарсан.

Хэсгийн дүн		66,175,058.0	
Төхижилт, гэрэлтүүлэг			
16	Нэгдсэн эмнэлгийн гадна зам талбайн засвар, арчлалт (Түргэн тусламжийн авто машины зам талбай)	18,900,000.0	Түргэний хаалганаас авто замын уулзвар хүртэл авто зам засвар, шинэчлэлийн ажил гүйцэтгэх шаардлагатай. Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/49 дугаар захирамжийг санхүүжүүлэх зардал
17	Булган сумын гэр хороололын гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх А хэсэг	19,600,000.0	Аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.4.5.1-д тусгагдсан. Булган сумын 6-р багийн А,Б,В хэсгийн гэрэлтүүлэг. Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/49 дугаар захирамжийг санхүүжүүлэх зардал
18	Булган сумын төвд нийтийн эзэмшлийн 2000 м2 авто зогсоолын талбай байгуулах.	19,200,000.0	Аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 1.2.5.4-д тусгагдсан. Жил ирэх тусам хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээлэн буй орчныг сайжруулах шаардлагатай. Энэ онд 960 м2. Аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.4.10.1-т тусгагдсан. Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/49 дугаар захирамжийг санхүүжүүлэх зардал
19	Амрах чөлөөт цагийн талбайн А хэсгийн тохижилт (Булган сумын соёлын амралтын цэцэрлэгт хүрээлэн.)	20,000,000.0	2 суманд тоглоомын талбай байгуулна. Аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.4.4.2-т тусгагдсан. Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/49 дугаар захирамжийг санхүүжүүлэх зардал
20	Сансар 1, 2-р садны дагуух гэрэлтүүлэг, тохижилтын ажлын зураг төсөв.	19,500,000.0	Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд амралт, аялал жуулчлалын маршрутат тусгагдсан. Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/49 дугаар захирамжийг санхүүжүүлэх зардал
Хэсгийн дүн		97,200,000.0	
Инженер геологи, дэвсгэр зураг, паспортжуулах, бусад зардал.			
21	Барилга байгууламжийн ажлын төсөв шинэчлэх, шаардлагатай ажлын зураг төсөв боловсруулах зардал	10,000,000.0	2022 оноос өмнөх ажлын зураг төсөвийг шинэчлэх зурдал (шаардлагатай тухай бүр), байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас зайлшгүй зураг төсөл боловсруулах шаардлага үүссэн нөхцөлд
22	1:1000 масштабтай дэвсгэр зураг	2,000,000.0	Барилга байгууламжийн төсөл хөтөлбөрийн дэвсгэр зургийн тодруулга, зураггүй газар дэвсгэр зураг гүйцэтгэх.
23	Инженер геологи 10 байршилд	20,000,000.0	Зураг төсвийн ажилд шаардлагатай инженер геологийн судалгааны ажлын зардал
24	Техникийн нөхцөл 12 барилгын зураг төсөлд	1,000,000.0	Зураг төсөл зохиоход шаардлагатай техникийн нөхцөлийн зардал

25	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд ороогүй инженерийн хийцлэлтэй барилга байгууламж, тохижилтын гүйцэтгэлийн кадастрын нөхөн бүрдүүлэлт	11,915,382.0	Хяналтын геодези хийгдээгүй инженерийн хийцлэлтэй барилга, дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламжийн мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд оруулж нөхөн бүрдүүлэлт хийх. Барилга хот байгуулалтын сайдтай байгуулсан гэрээний биелэлт хангуулах.
Хэсгийн дүн		44,915,382.0	
Шилжих зураг төслийн санхүүжилт			
26	Жаргалант зуслангийн уран тогоо хотхон	3,500,000.0	Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн А/693 тоот захирамжийн үлдэгдэл санхүүжүүлт.
27	Жаргалант зуслангийн олимп хотхон	4,000,000.0	Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн А/693 тоот захирамжийн үлдэгдэл санхүүжүүлт.
28	Жаргалант зуслангийн сансар хотхон	3,500,000.0	Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн А/693 тоот захирамжийн үлдэгдэл санхүүжүүлт.
29	Аймгийн ЗДТГ-ын Б,В блокийн дээврийн их засварын зураг төсөв	3,800,000.0	Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн А/693 тоот захирамжийн үлдэгдэл санхүүжүүлт.
30	Аймгийн ЗДТГ-ын Г блокийн зоорины давхарын дахин төлөвлөлтийн засварын зураг төсөв	3,980,000.0	Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн А/693 тоот захирамжийн үлдэгдэл санхүүжүүлт.
31	Аймгийн ЗДТГ-ын фасадын шинэчлэлийн зураг төсөв	3,980,000.0	Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн А/693 тоот захирамжийн үлдэгдэл санхүүжүүлт.
32	Жаргалант зуслангийн барилгуудын инженер геологийн зардал	13,129,160.00	Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 06-ний өдрийн А/810 тоот захирамжийн санхүүжүүлэх зардал
33	Аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан бүтээн байгуулалтын ажлын зураг төслийн өмнөх инженер геологи	11,048,400.00	Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дугаар сарын 24-ний өдрийн А/288 тоот захирамжийн санхүүжүүлэх зардал
Хэсгийн дүн		46,937,560.0	
Нийт дүн		661,678,000.0	Төсөвт өртөг.